



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/395

Чингис хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 06 дугаар хуралдааны “Аймгийн 2021 оны төсвийн тодотгол батлах тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 06 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтаас сум, тосгодод эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, цахим системийн худалдан авах төлөвлөгөөний хугацааны дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга, тосгодын Захирагч нарт даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Батсайхан)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011013

| Д/д | Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр | Хугацаа | | Төсөвт өртөг | 2021 онд санхүүжих | Эрх шилжүүлсэн ТЭЗ |
|------------------------------------|--|---------|--------|------------------|-----------------------|-------------------------------------|
| | | Эхлэх | Дуусах | | | |
| Орон нутгийн төсөв | | | | | | |
| Тоног төхөөрөмж | | | | | | |
| 1 | Цусны анализатор (Жаргалтхаан сум ЭМТ) | 2021 | 2021 | 15,000.0 | 15,000.0 | Жаргалтхаан сумын Засаг дарга |
| 2 | Халаалтын тогоо (Өлзийт тосгон) | 2021 | 2021 | 24,000.0 | 24,000.0 | Хэрлэн сумын Засаг дарга |
| 3 | Тавилга, тоног төхөөрөмж (Галшар сум, ЗДТГ) | 2021 | 2021 | 20,000.0 | 20,000.0 | Галшар сумын Засаг дарга |
| 4 | Автомашин (Мөрөн сум) | 2021 | 2021 | 70,000.0 | 70,000.0 | Мөрөн сумын Засаг дарга |
| 5 | Автомашин (Биндэр сум) | 2021 | 2021 | 70,000.0 | 70,000.0 | Биндэр сумын Засаг дарга |
| 6 | Автомашин (Галшар сум) | 2021 | 2021 | 70,000.0 | 70,000.0 | Галшар сумын Засаг дарга |
| Хөтөлбөр, төсөл арга хэмжээ | | | | | | |
| 7 | Цэвэрлэх байгууламжийн геологи, хайгуулын зардал (Бэрх тосгон) | 2021 | 2021 | 15,000.0 | 15,000.0 | Бэрх тосгоны захирагч |
| Нийт дүн | | | | 284,000.0 | 284,000.0 | |